

UCS 1103B:2020


НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ



Эрүүл мэндийн байгууллагын гадна орчны
ерөнхий шаардлага

НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ

Эрүүл мэндийн байгууллагын гадна орын
ерөнхий шаардлага



ГАРЧИГ

Оршил.....	5
1. Зорилго	6
2. Хамрах хүрээ.....	6
3. Норматив эшлэл	6
4. Нэр томъёоны тодорхойлолт	7
5. Эрүүл мэндийн байгууллагын төрөл ангилал.....	7
6. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага	8
7. Байршил	9
8. Эдэлбэр газрын хэмжээ.....	10
9. Үйлчлэх хүрээ.....	11
10. Гадна орчны төлөвлөлтийн ерөнхий шаардлага.....	12
11. Үерээс хамгаалах, борооны ус зайлуулах байгууламж.....	13
12. Барилгын гол хаалга, гадна довжоо	14
13. Явган хүний зам	16
14. Авто зам, замын орц гарц	17
15. Авто зогсоол	18
17. Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж.....	20
18. Эмнэлгийн хашаа, хайс	21
19. Сандал, сүүдрэвч.....	22
20. Гадна орчны зам талбайн гэрэлтүүлэг	23
21. Байгууллагын нэрийн тэмдэг, байршлын мэдээлэл	24
22. Байгууллагын нэрийн бичвэр.....	26
23. Хог хаягдал.....	27
24. Онцгой нөхцөлд тавигдах шаардлага.....	32
24.1 Нисдэг тэрэгний зурвас.....	32
24.2 Галын аюулгүй байдал	32
24.3 Гамшгаас хамгаалах арга хэмжээ	34
25. Теле хяналтын камер	35
26. Тамхи татах цэг	36
26. Шалгуур үзүүлэлт.....	37
Ашигласан материалын жагсаалт	39

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хэвтэн эмчлүүлэх эмнэлгийн эдэлбэр газрын хэмжээ	10
Хүснэгт 2. Поликлиникийн эдэлбэр газрын хэмжээ	10
Хүснэгт 3. Дагуу налуугийн хэмжээ	15
Хүснэгт 4. Авто зогсоолоос эмнэлэг хүртэлх зай	18
Хүснэгт 5. Эрүүл мэндийн байгууллагын авто зогсоолын норм	19
Хүснэгт 6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан авто зогсоолын норматив	19
Хүснэгт 7. Нийтийн эзэмшлийн сандлын стандарт хэмжээ	23
Хүснэгт 8. Гэрэлтүүлгийн өндөр болон байрлуулах зай	23
Хүснэгт 9. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн нэр хамаарах арга зүйн удирдамжийн дугаар	24
Хүснэгт 10. Дахивар хог ангилан ялгах тэмдэг	30
Хүснэгт 11. Гадна орчны тохижилтыг хүлээн авах шалгуур үзүүлэлт	37

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Эмнэлгийн гадна орчин	9
Зураг 2. Эмнэлгийн үйлчлэх хүрээ	11
Зураг 3. Үерээс хамгаалах борооны ус зайлуулах байгууламжийн төлөвлөлт	13
Зураг 4. Үерээс хамгаалах менежментийн төлөвлөгөө	14
Зураг 5. Барилгын орц, гадна довжоо, налуу замын стандарт	15
Зураг 6. Налуугийн хэмжээ	15
Зураг 7. Явган хүний замын стандарт	16
Зураг 8. Эмнэлгийн орц гарцын схем	17
Зураг 9. Эмнэлэгийн авто зогсоолын харагдах байдал	18
Зураг 10. Авто зогсоолын харагдах байдал	19
Зураг 11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний зогсоолын таних тэмдэг	20
Зураг 12. Ногоон байгууламж	20
Зураг 13. Эмнэлгийн хашааны төрөл	21
Зураг 14. Сандал, сүүдрэвчний харагдах байдал	22
Зураг 15. Байгууллагын нэрийн тэмдэг	24
Зураг 16. Мэдээллийн самбар, хэмжээ	25
Зураг 17. Байгууллагын нэрийн бичвэрийн жишээ	26
Зураг 18. Эмнэлгийн хог хаягдлыг таних тэмдэг	27
Зураг 19. Эмнэлгийн хог хаягдал түр хадгалах цэгийн харагдах байдал/ жишээ зураг	29
Зураг 20. Ангилан ялгах тэмдэг бүхий хогийн сав	31
Зураг 21. Хог хаягдал ангилах цэгийн харагдах байдал	31
Зураг 22. Эмнэлгийн нисдэг тэрэгний зурвас	32
Зураг 23. Гал унтраах анхан шатны багаж	34
Зураг 24. Гамшгийн үед цугларах талбайн таних тэмдэг	35
Зураг 25. Теле хяналтын камер	35
Зураг 26. Утаат тамхи татахыг хориглосон болон зөвшөөрсөн цэг анхааруулах тэмдэг	36

ОРШИЛ

Монгол улсын иргэн бүр эрүүл чийрэг байхын тулд урьдчилан сэргийлэх, эмчлэх, нөхөн сэргээх зэрэг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй үйлчилгээнд хаана амьдарч байгаагаас үл хамааран олон улсын стандартад нийцсэн эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах шаардлагатай.

Эрүүл мэндийн байгууллага, эмчилгээ үйлчилгээ, оношилгооны үйл ажиллагаатай холбоотой үндэсний стандарт, Барилгын норм ба дүрэмд үйл ажиллагааны зохион байгуулалт, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тогтолцоо, орчны эрүүл ахуйн шаардлагыг тодорхойлсон бөгөөд эрүүл мэндийн байгууллагын гадна орчинд тавигдах шаардлага, зохицуулалт дутагдалтай байна.

Иймд эрүүл мэндийн үйлчилгээнд хот төлөвлөлт, хот байгуулалтын талаас гадна орчинд тавигдах ерөнхий шаардлагыг тодорхойлж эмнэлгийн барилгыг төлөвлөх, байршил газрын хэмжээг тогтоох, зураг төсөл боловсруулах үе шатнаас эхлэн дээрх асуудлыг цогцоор тусган хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдамж арга зүйгээр хангах зорилгоор энэхүү баримт бичгийг боловсруулав.

НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ

Эрүүл мэндийн байгууллагын гадна орчин

1. ЗОРИЛГО

Энэхүү баримт бичгийн зорилго нь эрүүл мэндийн байгууллагын гадна орчинд тавигдах ерөнхий шаардлагыг тодорхойлж, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчлүүлж буй иргэдэд ая тухтай, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхэд оршино.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

Эмнэлэг эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын барилгыг төлөвлөх, эдэлбэр газрын байршил хэмжээг тогтоох, ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл боловсруулах, зам замын байгууламж, барилга болон гадна орчны тохижилтын ажил гүйцэтгэхэд хэрэглэх бөгөөд улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагууд өмчийн хэлбэр үл харгалзан мөрдлөг болгоно.

3. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Удирдамж арга зүйн баримт бичигт дараах хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт, барилгын норм ба дүрэм баримт бичгүүдийг хэрэглэв. Эш татсан стандарт, норм дүрэмд өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн сүүлийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хууль
- БД 31-115-12 – Эмнэлгийн барилга
- БНБД 30-01-04 – Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм
- БНБД 21-05-10 – Авто зогсоол
- БД 31-112-11 – Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох норм
- БНБД 31-03-03 – Олон нийт иргэний барилга
- MNS 5973:2009 – Барилга байгууламжид ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ түвшин
- MNS 6056:2009 – Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар
- MNS 6392:2013 – Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага
- MNS 5095:2017 – Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа
- UCS 1404C:2020 – Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулах сандалд тавигдах шаардлага
- UCS 1403C:2020 – Нийтийн эзэмшлийн гудамж талбайд байршуулах хогны саванд тавигдах шаардлага
- UCS 0901B:2020 – Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтанд тавигдах шаардлага

- UCS 0001-02:2019 – Хашаа, хайс, хашлагад тавигдах ерөнхий шаардлага, хэрэглээ
- UCS 0902B:2020 – Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах шаардлага

4. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Эмнэлэг – гэж эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;

Нэгдсэн эмнэлэг – гэж хүн амд 7-оос доошгүй үндсэн мэргэшлээр эмнэлгийн 3 лавлагаа тусламж, үйлчилгээг амбулаториор болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг;

Өрхийн эмнэлэг – гэж харьяалагдах нутаг дэвсгэрийн хэмжээнд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний шатлалын нэгжийг;

Өдрийн эмчилгээний хэсэг – гэж амбулатори-поликлиник ба хэвтэн эмчлүүлэх байгууллагын бүрэлдэхүүнд ордог, эмнэлгийн хяналтад 24 цагаар байлгах шаардлагагүй үйлчлүүлэгчид урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх ба нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх хэсгийг;

Хэвтэн эмчлүүлэх хэсэг – гэж эмнэлэгт хэвтсэн өвчтөнүүдэд эмнэлгийн тусламж үзүүлэхэд зориулсан өрөө болон эмчилгээний өрөө тасалгаануудаас бүрдэх эмнэлгийн бүтцийн бүрэлдэхүүн хэсгийг;

Эмнэлгийн тусламж, үйлчилгээ – гэж өвчин эмгэг, гэмтэл бэртэл, хүний биеийн үйл ажиллагааны алдагдлыг орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд тулгуурлан оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх, сэргээн засах цогц үйл ажиллагааг;

Эмнэлгийн барилгын зураг төсөл боловсруулах зургийн даалгавар – гэж норм ба дүрмийн шаардлагын дагуу боловсруулсан, төлөвлөж буй эмнэлгийн барилгын өрөө тасалгааны жагсаалт, тэдгээрийн хүчин чадал, талбайн хэмжээг тусгасан баримт бичгийг;

Аж ахуйн хэсэг – гэж эмнэлгийн байгууллагын үйл ажиллагааг хангахад зориулсан (хоол бэлдэх алба, угаалга, ариутгалын тасаг, агуулахын өрөөнүүд бүхий ханган нийлүүлэх алба, эмнэлгийн хаягдлыг түр хадгалж, боловсруулах алба, автомашины битүү зогсоол, барилгын үйл ажиллагааг хангах инженерийн алба) хоорондоо холбоотой бүлэг өрөө, тасалгаануудыг;

Технологийн шат – гэж барилга байгууламжийн давхруудыг хооронд нь технологийн уялдаа холбоог хангах зориулалтаар холбосон, хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх болон ослын үед авран хамгаалах ажил хийхэд зориулаагүй шатыг;

Галын аюулгүй бүс – гэж барилгын дотор буюу гадна талд байгаа хүмүүсийг галын аюултай нөлөөллөөс хамгаалсан, эсвэл тийм нөлөөлөл байхгүй буюу байж болох дээд хэмжээг давдаггүй бүсийг;

5. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТӨРӨЛ АНГИЛАЛ

- 5.1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагыг “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ” болон “Эмнэлгийн тусламж үйлчилгээ” гэсэн хоёр ерөнхий төрөл байна. (*Эрүүл мэндийн тухай хууль 13.1*)
- 5.2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэдэг нь хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг

дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа хамаарна.

- 5.3. Эмнэлгийн тусламж үйлчилгээ гэдэгт өрхийн эрүүл мэндийн, эмнэлгийн мэргэшсэн, эх барихын, эмнэлгийн яаралтай, сувилахуйн дагнасан, түргэн тусламжийн, сэргээн засахын гэсэн төрөлтэй байна.
- 5.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага дараах 14 төрөлтэй байна. *(Эрүүл мэндийн тухай хууль 15.1) Үүнд:*
 - 5.4.1. Өрхийн эрүүл мэндийн төв;
 - 5.4.2. Сум, тосгоны эрүүл мэндийн төв;
 - 5.4.3. Хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төв;
 - 5.4.4. Клиник;
 - 5.4.5. Амаржих газар;
 - 5.4.6. Нийгмийн эрүүл мэндийн төв;
 - 5.4.7. Нэгдсэн эмнэлэг;
 - 5.4.8. Сувилал;
 - 5.4.9. Түргэн тусламжийн төв;
 - 5.4.10. Сэргээн засах төв;
 - 5.4.11. Тусгай эмнэлэг;
 - 5.4.12. Тусгай мэргэжлийн төв;
 - 5.4.13. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг;
 - 5.4.14. Сувилахуйн төв;

6. ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА


Эрүүл мэндийн байгууллагыг шинээр болон шинэчлэн төлөвлөхдөө эмнэлгийн шатлал үйлчилгээг үл хамааран, үйлчлүүлэгчдийн эрүүл аюулгүй орчинд үйлчлүүлэх нөхцөл бололцоог хангаж, хотын нутаг дэвсгэр, архитектур, орон зайн тухтай орчин бий болгох үүднээс барилгын гадна орчны дараах зүйлсийг цогцоор нь төлөвлөж, барилгын ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- 6.1. Үерээс хамгаалах, борооны ус зайлуулах байгууламж;
- 6.2. Зам, замын байгууламж;
- 6.3. Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж;
- 6.4. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө;
- 6.5. Хаяг, хаягжилт, гэрэлтүүлэг чимэглэл;
- 6.6. Хог хаягдлын цэг;
- 6.7. Аюулгүй байдал, гэрэлтүүлэг, камержуулалт;

Эрүүл мэндийн байгууллагын байршил, үйлчлэх хүрээ, эдэлбэр газрын хэмжээг онцгойлон үзэж төлөвлөвөл зохино.

7. БАЙРШИЛ

- 7.1. Эмнэлгийн барилга байгууламжийг төлөвлөхдөө хот суурины хүн ам, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, нийслэлийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төслийн дагуу байршлыг тогтооно.
- 7.2. Хотын нутаг дэвсгэрийн хүн амын нягтралаас хамааруулан хүчин чадлыг тогтоож, эдэлбэр газрын хэмжээ, эдэлбэр газрын зохион байгуулалтыг холбогдох хууль, норм, дүрэм, стандартын дагуу төлөвлөнө.
- 7.3. Эрүүл мэндийн байгууллагыг шинээр байгуулах, өргөтгөх, одоо байгаа эмнэлгийн хүчин чадлыг нэмэгдүүлэхдээ хүн амын тоо, газарзүйн байршил, нутаг дэвсгэрийн онцлог, эрүүл мэндийн эрэлт хэрэгцээний судалгаанд тулгуурлан стандарт шаардлагыг алдагдуулахгүй байх нөхцөлийг хангаж зохион байгуулна. (Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам 1.1)
- 7.4. Тухайн бүс нутгийн нягтаршил, хүн амын тоо, үйлчлэх хүрээнээс хамааруулан эмнэлгийн байгууллагын хүчин чадлыг тодорхойлно.
- 7.5. Эрүүл мэндийн байгууллагыг хурдны замын хажууд барих болон төлөвлөхийг хориглоно.
- 7.6. Халдварт, сүрьеэ, сэтгэцийн эмгэг судлалын эмнэлгийг хүн амын суурьшлын бүсийн гадна байхаар төлөвлөнө.



Зураг 1. Эмнэлгийн гадна орчин

8. ЭДЭЛБЭР ГАЗРЫН ХЭМЖЭЭ

- 8.1. Хэвтэн эмчлүүлэх эмнэлгийн эдэлбэр газрын хэмжээг орны тооноос хамаарч (Хүснэгт 1)-ийн дагуу тооцно. /MNS 6392:2014 - 4.1.3/

Хүснэгт 1. Хэвтэн эмчлүүлэх эмнэлгийн эдэлбэр газрын хэмжээ

№	Орны тоо	Нэг оронд ногдох талбайн хэмжээ /м²/
1	50 хүртэл ортой	300
2	50-100 ортой	300-200
3	100-200 ортой	200-140
4	200-400 ортой	140-10
5	400-800 ортой	100-80
6	800-с дээш ортой	60

- 8.2. Поликлиникийн хүчин чадлаас хамаарч эдэлбэр газрын хэмжээг (Хүснэгт 2)-ын дагуу тооцно. /MNS 6392:2014 – 4.1.3/


Хүснэгт 2. Поликлиникийн эдэлбэр газрын хэмжээ

№	Поликлиникийн хүчин чадал	Эдэлбэр газрын хэмжээ /м²/
1	Нэг ээлжид 100 хүн үзэх	2500
2	Нэг ээлжид 150-200 хүн үзэх	3500
3	Нэг ээлжид 400 хүн үзэх	4500

- 8.3. Бүх эмнэлэгт хүүхдийн орны нормыг 1,5 болон амаржих газарт 0,7 итгэлцүүрээр үржүүлж төлөвлөнө.
- 8.4. Хотын төвд байрлах эмнэлгийн хувьд эдэлбэр газрын хэмжээг 25% хүртэл бууруулж төлөвлөж болно. /БНБД 31-03-03*/11/
- 8.5. Хүн амын суурьшлын бүсийн гадна эдэлбэр газрыг халдварт, хавдар судлалын эмнэлэгт 15 %-аар, сүрьеэ, сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт 25 %-аар, насанд хүрэгчдийн нөхөн сэргээх сувилалд 20 %-аар, хүүхдийн нөхөн сэргээх сувилалд 40 %-аар нэмэгдүүлэн төлөвлөж болно. Хүн амын суурьшлын бүс доторх эмнэлгийн эдэлбэр газрыг төлөвлөхдөө 25 % хүртэл бууруулж болно. /MNS 6392: 2014– 8.2.5/
- 8.6. Хүн амын суурьшлын бүсээс гадна эмнэлгийн эдэлбэр газрыг халдвар, хавдар судлалын эмнэлэгт 15%, сүрьеэ, сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт 25%, насанд хүрэгчдийн нөхөн сэргээх сувилалд 20%, хүүхдийн нөхөн сэргээх сувилалд 40%-аар тус тус нэмэгдүүлэн тооцож болно.
- 8.7. Хүн амын суурьшлын бүс доторх эмнэлгийн эдэлбэр газрыг төлөвлөхдөө 25% хүртэл бууруулж болно. /MNS 6392: 2014– 8.2.5/
- 8.8. Эмнэлгийн барилга дотор болон эмнэлгийн барилгын эдэлбэр газарт (халдвартын болон сүрьеэгийн эмнэлгээс бусад) өдрийн эмчилгээний өвчтөн, өвчтөний төрөл садан болон уригдаж ирсэн тусгай мэргэжилтнүүдийн байрлах амрах байр төлөвлөж болно.

9. ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ

- 9.1. Хэвтэж эмчлүүлэх эмнэлгийг хүн амын тооцоонд тулгуурлан төлөвлөх бөгөөд норматив хэмжээ нь хотод 1000 хүн тутам 9, үйлчлэх хүрээ нь 1 км, төслийн даалгавраар 2 км-ийн зайтай төлөвлөж болно.
- 9.2. Амбулатори, поликлиникийн эмнэлгийн норматив хэмжээ нь хотод 1000 хүн тутамд 35, 100 хүн үзлэг/өдөрт эдэлбэр газрын хэмжээ 0,1 га байх ба 0,3 га талбайгаас хэтрэхгүй. Үйлчлэх хүрээ нь багадаа 1 км байна. Нэгдсэн эмнэлэгт болон орон сууцны байрны 1 давхарт үйлчилгээний хэлбэрээр байршуулж болно. Төлбөртэй эмнэлгүүд төслийн даалгавраар байгуулагдаж байна.
- 9.3. Дотор, шүд, гэмтлийн эмнэлгийн үйлчлэх хүрээ 500-750 м байна.
- 9.4. Нэгдсэн эмнэлэг, амбулатори, амаржих газар хүртэл явганаар болон тээврийн хэрэгслээр хүрэлцэн очих хугацаа 30 минутаас хэтрэхгүй байхаар тооцно. (БНБД 30-01-04 Хот тосгоны төлөвлөлт)



Тайлбар: Хэвтэн эмчлүүлэх эмнэлгийг хүн амын тооцоонд тулгуурлан төлөвлөнө. 1000 хүн ам тутамд 9 ортой эмнэлэг байхаар тооцно.

Зураг 2. Эмнэлгийн үйлчлэх хүрээ

10. ГАДНА ОРЧНЫ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

№	Ерөнхий шаардлага	Өрхийн эмнэлэг;	Дүүргийн эмнэлэг; Эрүүл мэндийн төв;	Нэгдсэн эмнэлэг; Төрөлжсөн эмнэлэг; Амаржих газар;	Тусгай эмнэлэг Сэтгэц; Сүрьеэ; Халдварт;
1	Гадна хаягийн байгууламж	UCS2101B:2020 “Төрийн байгууллагын нэрийн тэмдэг”-т тавигдах шаардлагын дагуу хийж гүйцэтгэн байрлуулна.			
2	Авто зогсоол /Нормын доод хэмжээ, төлөвлөлтөөр нэмж төлөвлөж болно/	Амбулатори 100 үзлэг тутам 3	100 ор тутам 20	100 ор тутам 20	100 ор тутам 20
3	Явган хүний зам	Явган хүний замын дагуу налуу, налуугийн урт, эргэлттэй хэсэг, замын саад, гадаргуу зэргийг UCS 0901B:2020 баримт бичгийн дагуу тооцон төлөвлөсөн байна.			
4	Орц гарц	Үзлэгийн хэсгийн орцыг эдэлбэр газар руу орох орцтой ойрхон төлөвлөх нь тохиромжтой.	Эмнэлгийн гол орц руу, хүлээн авах хэсэг рүү, мөн аж ахуйн хэсэг рүү орох автомашины орцыг төлөвлөж өгнө.		Халдвар тараах өндөр эрсдэл бүхий материалын урсгалыг бусад хөдөлгөөний урсгалаас төлөвлөлтийн шийдлээр болон тусгай зориулалтын тоноглол, төхөөрөмжөөр сайтар тусгаарлаж өгнө.
5	Хашаа, хайс	Эдэлбэр газрын дагуу ногоон байгууламж байж болно.	Хэвтэн эмчлүүлэх хэсэгтэй эмнэлгийн барилга мөн түүнчлэн сувиллын эдэлбэр газар хашаагаар хүрээлэгдсэн байх хэрэгтэй Хэвтэн эмчлүүлэх хэсэгтэй эмнэлгийн хашааны өндөр 1.6м-с багагүй байна. Эмнэлгийн хашаа нь энгийн шугаман, авирахаас хамгаалсан бат бөх хийцтэй хашаа байна.		Сэтгэц мэдрэлийн хэвтэн эмчлүүлэх эмнэлгийн эдэлбэр газрын хашаа нь гудамж талаас барилга харагдахгүйгээр төлөвлөгдөх ёстой. Сэтгэц мэдрэлийн хэвтэн эмчлүүлэх эмнэлгийн хашааны өндөр 2.5м-с багагүй байна.
6	Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж	Эдэлбэр газрын хилийн дагуу, барилгажаагүй хэсгүүдэд ногоон байгууламж төлөвлөнө. Барилгын цонхноос модыг 15м-с багагүй, бутыг 5м-с багагүй зайнд байрлуулж суулгана. Удаан хугацаагаар хэвтэн эмчлүүлдэг эмнэлгийн барилгажаагүй сул талбайн 50 хувиас багагүй талбайд ногоон байгууламж төлөвлөнө.			Удаан хугацааны эмчилгээ хийдэг эмнэлгийн (сэтгэц мэдрэлийн, сүрьеэгийн, нөхөн сэргээх эмчилгээний) эдэлбэр газарт ногоон байгууламж бүхий цэцэрлэг төлөвлөнө.

7	Гадна орчны гэрэлтүүлэг	Гэрэлтүүлгийн төрөл ангилал, ган багана, өнгө, суурьлуулах техник зэргийг Монгол улсын үндэсний стандарт MNS2568:1983 “Гэрэлтүүлгийн ган багана. Техникийн шаардлага” болон UCS 1901B:2020 “Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд байршуулах гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавигдах шаардлага”-ыг хангасан байна.
8	Сандал сүүдрэвч	Сандлыг байрлуулах нь нээлттэй орон зайн сүлжээгээр явган зорчигчийн хөдөлгөөний эрчмийг дэмжих явдал бөгөөд үзэгдэх орчин сайтай, нам гүм болон чимээ шуугиан ихтэй газар суух сонголтуудыг бий болгосон байх. UCS 1404C:2020 Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулах сандалд тавигдах шаардлага /дэлгэрүүлж үзэх/
9	Эмнэлгийн хог хаягдал	Түр хадгалах байр эсвэл түр хадгалах цэгтэй байхаар төлөвлөнө.
10	Энгийн хог хаягдал	Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага стандартын дагуу тээвэрлүүлнэ.

11. ҮЕРЭЭС ХАМГААЛАХ, БОРООНЫ УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖ

- 11.1. Эрүүл мэндийн барилга байгууламжийн байршлыг төлөвлөхөд “Үерээс хамгаалах байгууламжийг төлөвлөх удирдамж” UCS 0502A:2020 -ийг мөрдлөг болгоно.
- 11.2. Үерийн эрсдэл бүхий газар, голын сав, үерийн усны урсац бүрэлдэх газарт эрүүл мэндийн барилга байгууламж барьж байгуулахыг хориглох бөгөөд тус барилга байгууламжийг Зураг 3-т үзүүлсний дагуу эрсдэл багатай бүсэд байгуулна.



Зураг 3. Үерээс хамгаалах борооны ус зайлуулах байгууламжийн төлөвлөлт

- 11.3. Аливаа барилгажилтын үйл ажиллагаа нь үерийн нөлөөллийг эрчимжүүлэх ёсгүй бөгөөд барилга байгууламж төлөвлөх нутаг дэвсгэрийн үнэлгээний хүрээ, арга технологийг тогтоож, үерийн гамшигт автах эрсдэлийг бууруулж борооны ус зайлуулах байгууламжийг төлөвлөнө.
- 11.4. Төлөвлөлтийг гүйцэтгэхдээ иргэд болон онцгой байдлын албан хаагчдад учирч болох үерийн эрсдэлийг аюулгүйн хэмжээнд байлгах, барилга байгууламж түүнд холбогдох дэд бүтцэд үерийн хохирол учрахаас сэргийлэх эсвэл болзошгүй хохирлыг багасгахаар тооцож төлөвлөнө.
- 11.5. Төслийн төлөвлөж байгаа талбайд хурсан борооны ус нь ойролцоох болон усны урсгалын доод хэсэгт байрлах барилга байгууламжид нөлөөлөхгүй байх ёстой.
- 11.6. Барилга, зам, талбайн үерээс хамгаалах болон борооны ус зайлуулах дэд бүтэц


барьж байгуулах нь эцсийн шийдэл биш бөгөөд тасралтгүй шинэчлэлт хөгжүүлэлт, тогтмол арчилгаа, засвар үйлчилгээ хийх шаардлагатай.



Зураг 4. Үерээс хамгаалах менежментийн төлөвлөгөө

12. БАРИЛГЫН ГОЛ ХААЛГА, ГАДНА ДОВЖОО

- 12.1. Эрүүл мэндийн байгууллагын барилгын гол хаалга болон гадна довжоог шинээр хийх болон шинэчлэх ажилд “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин” MNS 6055:2009 болон “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэд бүтцийн хүртээмжийг дээшлүүлэх арга зүй” UCS 1001A -ийг мөрдлөг болгоно.
- 12.2. Эрүүл мэндийн байгууллагын барилгын гол хаалга нь олоход хялбар, шинээр баригдах барилгын бүх орц хөгжлийн бэрхшээлтэй, тэргэнцэртэй иргэн саадгүй нэвтрэх боломжтой байх ёстой бол, хуучин барилгын гол орох хаалга нь дээрх шаардлагыг хангасан байх ёстой.
- 12.3. Гол хаалга нь тухайн орчны явган хүний зам, авто зам, замын байгууламж, авто зогсоол, бууж суух талбай болон нийтийн тээврийн зогсоолтой холбогдсон байх ба олон давхар барилгад тохиромжтой байрлалтай цахилгаан шат уруу нэвтрэх боломжийг олгосон байна.
- 12.4. Барилгын үүдний өрөөний шалны түвшин орц уруу орох явган хүний замын түвшнээс 15 см -ээс багагүй өндөр байх ёстой бөгөөд шатны гишгүүрийн тоо 3 -аас багагүй, 18 -аас ихгүй байна. Гишгүүрийн өргөн 25 см -ээс багагүй, өндөр 15 см -ээс багагүй ба 18 см -ээс ихгүй байна.
- 12.5. Эмнэлэгт тэргэнцэртэй иргэн хэн нэгний тусламжгүйгээр нэвтрэх боломжийг хангаж шалны хоорондох уналтын зөрүү 4 см -ээс их бол налуу зам хийх ба зам нь 1x12 харьцаа бүхий налуутай байна. Барилгын орц, гадна довжоо, налуу замын стандарт зай хэмжээ, харагдах байдлыг Зураг 5 -т үзүүлэв.




Зураг 5. Барилгын орц, гадна довжоо, налуу замын стандарт

12.6. Шатны гишгүүр, шатны налуу болон талбайд бариултай хашлага байх ёстой мөн өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан шатны нэмэлт бариулыг төлөвлөнө. Шатны бариулын стандарт зай хэмжээг Зураг 6-т үзүүлэв.

12.7. Явган хүний замыг тодорхой уртад 9000 мм интервалаар 6%-8%, 12000 мм интервалаар 5%-6% дагуу налуутай байхаар шаталсан хэлбэрээр төлөвлөнө. Налуу замыг халтирахаас сэргийлсэн гадаргуутай байхаар гүйцэтгэнэ. Дагуу налуу 6%-с дээш тохиолдолд бариул нэмэлтээр төлөвлөнө. Явган хүний замын дагуу налууугийн хэмжээ 3-р хүснэгт заасан утгатай байна.

Хүснэгт 3. Дагуу налууугийн хэмжээ


Дагуу налууугийн урт	Явган хүний замын дагуу налуу
9000 мм (9 м)	6% - 8%
12000 мм (12 м)	5% - 6%
15000 мм (15 м)	4% - 5%



Зураг 6. Налууугийн хэмжээ

13. ЯВГАН ХҮНИЙ ЗАМ

- 13.1. Эрүүл мэндийн байгууллагын гадна орчинд явган зорчигчийн аюулгүй байдал, саадгүй зорчих нөхцөлийг хангасан явган хүний замын тасралтгүй үргэлжлэх сүлжээ байх ёстой бөгөөд энэ ажилд “Хот суурины гудамж зам талбайн төлөвлөлт” БНБД 32-04-06 болон “Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавигдах шаардлага” UCS 0901B -ийг мөрдлөг болгоно.
- 13.2. Эдэлбэр газрын талбайн хэмжээгээр хүрээлсэн хашаатай, явган хүн болон өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, тэргэнцэртэй үйлчлүүлэгчдэд зорчих нөхцөл боломж хангагдсан цардмал зам төлөвлөнө.
- 13.3. Явган хүний замын өргөнийг тухайн гудамжны хөдөлгөөний урсгал ачааллаас хамааруулан тогтоох бөгөөд хамгийн багадаа 1.5 м байна.
- 13.4. Явган хүний зам, талбайн гадаргын түвшний зөрүү 4 см -ээс илүүгүй байх бөгөөд 4 см -ээс их бол налуу зам хийнэ.
- 13.5. Явган замын дагуу замын мэдээлэх болон анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ болон тухайн орчны байршил, чиглэлийн мэдээллийг агуулсан мэдээллийн самбарыг харагдахуйц газарт байрлуулсан байна.
- 13.6. Зорчигчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор явган хүний замыг авто тээврийн хэрэгсэл зорчих хэсгээс тусгаарласан хаалт, хашилт суурилуулна.
- 13.7. Харааны бэрхшээлтэй хүнд зориулсан хөтөч хавтанг заавал төлөвлөнө. Хөтөч хавтанг тасралтгүй үргэлжлүүлэн төсөллөх ба одоо байгаа явган хүний замтай зайлшгүй уялдуулах, боломжгүй тохиолдолд тэдгээр замуудын хөтөч хавтанг шинээр төлөвлөх, налуу зам хийх зэргээр төсөллөнө.



Зураг 7. Явган хүний замын стандарт

- 13.8. Гарцын хашлаганы намсгасан хэсгийн өргөн нь 1500 мм байна. Гэхдээ явган зорчигчдын хөдөлгөөний эрчим багатай газарт, зайлшгүй тохиолдолд 1220 мм хүртэл богиносгохыг зөвшөөрнө. Явган хүний гарц хэсгийн хажуу талын налууулсан

гадаргуу нь хамгийн ихдээ 1:10 байна. Гарцын тэгш хэсэг тэргэнцэртэй хүмүүс зорчиход чөлөөтэй байх үүднээс хамгийн багадаа 1500 мм х 1500 мм харьцаатай байна.

14. АВТО ЗАМ, ЗАМЫН ОРЦ ГАРЦ

- 14.1. Барилга байгууламж уруу орох авто замын гарцыг төлөвлөхдөө тухайн газрын батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу авто замын хөдөлгөөн болон явган зорчигчийн хөдөлгөөнтэй уялдуулж төлөвлөнө.
- 14.2. Эмнэлгийн гол орц руу, хүлээн авах хэсэг рүү, мөн аж ахуйн хэсэг рүү орох автомашины орцыг төлөвлөж өгнө. Эмгэг судлалын хэсэг рүү орох орцыг аж ахуйн орцтой нэгтгэж хийхийг зөвшөөрнө. (Зураг 8)
- 14.3. Нэгдсэн эмнэлгийн поликлиникин үзлэгийн хэсгийн орцыг эдэлбэр газар руу орох орцтой ойрхон төлөвлөх нь тохиромжтой.
- 14.4. Эмнэлгийн барилгын эдэлбэр газрын орц ба гарц дээр видео хяналтын камер бүхий автоматаар өргөгддөг хаалт байрлуулна. Зургийн даалгаварт заагдсаны дагуу тусгай төхөөрөмжөөр тоноглогдсон нэвтрэх хэсгийг төлөвлөж болно. Халдвартын эмнэлгийн эдэлбэр газраас гарах гарц дээр авто тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх төхөөрөмж төлөвлөнө.
- 14.5. Эмнэлгийн ажилтнууд болон үйлчлүүлэгчдийн орцыг тусдаа төлөвлөж байгаа тохиолдолд автомашины зогсоол нь тухайн орцтойгоо ойрхон байрлах нь тохиромжтой.
- 14.6. Өвчтөнийг эмнэлгээс гаргахдаа хэвтэн эмчлүүлэх хэсгээс гаргана. Эмнэлэг-технологийн даалгавраар гаргах өрөө тасалгаа төлөвлөж болно.



Зураг 8. Эмнэлгийн орц гарцын схем

15. АВТО ЗОГСООЛ

15.1. Эмнэлгийн байгууллагын гадна зогсоолыг төлөвлөхдөө иргэдэд хүртээмжтэй, чирэгдэлгүй, шуурхай байдлаар тав тухтай орчинд үзүүлэх нөхцөл боломжийг онцгойлон анхаарч “Хот тосгоны барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30-01-04 болон “Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах шаардлага” UCS 0902В -ийг мөрдлөг болгоно.

15.2. Эдэлбэр газарт автомашины зогсоолыг байрлуулахдаа түргэн тусламжийн машины зогсоолыг яаралтай тусламжийн тасгийн орцонд ойр, эмнэлгийн үйлчилгээний автомашины зогсоолыг аж ахуйн орцонд ойр, эмнэлгийн ажилтны зогсоолыг ажилчдын орцонд ойр, үйлчлүүлэгчдийн зогсоолыг үйлчлүүлэгчдийн орцонд ойр байрлуулбал зохино. Авто зогсоолууд нь барилгад галын машин орох гарцыг хааж байрлаж болохгүй.

15.3. Авто зогсоолоос эмнэлэг хүртэлх зайг Хүснэгт 4-т үзүүлэв.

Хүснэгт 4.Авто зогсоолоос эмнэлэг хүртэлх зай

Барилга байгууламж	Зогсоолын тоо		
	10 хүртэл	11-50	51-с дээш
Эмнэлгийн барилга	25 м-ээс багагүй	50 м-ээс багагүй	*

15.4. Эмнэлгийн барилгын эдэлбэр газарт аж ахуйн ба эмнэлгийн хог хаягдлыг зайлуулах, хангамжийн болон аж ахуйн машинуудад зориулсан аж ахуйн талбайг тусад нь төлөвлөж өгнө.



Зураг 9. Эмнэлгийн авто зогсоол харагдах байдал

15.5. Эрүүл мэндийн байгууллагын авто зогсоолыг хүснэгт 5-ын дагуу төлөвлөх бөгөөд зогсоолын тоог нормативын хамгийн бага хэмжээгээр тусгасан болно. Шаардлагатай тохиолдолд нэмж төлөвлөж болно.

Хүснэгт 5. Эрүүл мэндийн байгууллагын авто зогсоолын норм

Эмнэлгийн байгууллагын нэр	Хүчин чадал	Зогсоолын тоо
Улсын, бүсийн, хотын, аймгийн, дүүргийн түвшний хэвтэн эмчлүүлэх эмнэлэг (нэгдсэн эмнэлэг, диспансер, төрөх эмнэлэг гэх мэт)	100 ажилтан 100 ор	30-40
Амбулатори поликлиникийн байгууллагууд	100 ажилтан 100 үзлэгт	5-7 2-3



Зураг 10. Авто зогсоолын харагдах байдал

15.6. Нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийн гадна зогсоолд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан авто зогсоолыг төлөвлөх бөгөөд тухайн зогсоолын хүчин чадлаас хамааруулан Хүснэгт 6-д заасны дагуу тооцож төлөвлөнө. (БД 31-112-11, 3.4).

Хүснэгт 6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан авто зогсоолын норматив

№	Зогсоолын тоо	Нийт зогсоолд эзлэх хувь, зогсоолын тоо
1	100 хүртэл	4% буюу 1 -ээс багагүй
2	101 - 200 хүртэл	3%
3	201 - 1000 хүртэл	2%
4	1000 -аас дээш	100 шин тутамд 1%, нэмж 20 машинаас ихгүй

15.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тээврийн хэрэгсэл байршуулахад зориулсан зогсоолыг явган хүний гарц болон сургуулийн барилгад ойр байхаар төлөвлөх нь зүйтэй.

15.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан авто зогсоолыг барилга байгууламжийн гол орц, хаалга хүртэл хамгийн ойр боломжит зайд төлөвлөх бөгөөд зогсоолын талбайд тусгай өнгө бүхий "Тэргэнцэртэй иргэн" замын тэмдэг тэмдэглэлээр ялгасан байна. (Зураг 11)



Зураг 11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний зогсоолын таних тэмдэг

16. ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖ

- 16.1. Эдэлбэр газрын хилийн дагуу, барилгажаагүй хэсгүүдэд ногоон байгууламж төлөвлөнө. Барилгын цонхноос модыг 15м-с багагүй, бутыг 5м-с багагүй зайнд байрлуулж суулгана.
- 16.2. Хүний эрүүл мэндэд харшил үүсгэдэггүй ногоон мод, бутыг сонгон, барилгаас 6-10 метрийн зайд, 2 цонхны хоорондох хананы тушаа, өндөр ургасан үедээ цонхонд бүдэг сүүдэрлэлт үүсгэх, харшлын бодис саармагжих орчинд тарина.
- 16.3. Эдэлбэр газрын барилгажаагүй сул талбай дахь ногоон байгууламжийн хэмжээг эмнэлгийн байгууллагын төрөл болон эмчилгээний хүчин чадлаас хамааруулан тооцно.
- 16.4. Эрчимт эмчилгээний хэвтэн эмчлүүлэх эмнэлэгт ногоон байгууламжийн талбайн хэмжээг нормчлохгүй. Удаан хугацаагаар хэвтэн эмчлүүлдэг эмнэлгийн барилгажаагүй сул талбайн 50 хувиас багагүй талбайд ногоон байгууламж төлөвлөнө.



Зураг 12. Ногоон байгууламж


- 16.5. Барилгажилтын нягтрал ихтэй, ногоон байгууламж төлөвлөхөд хязгаарлагдмал тохиолдолд дээвэр дээрх болон өвлийн цэцэрлэгийг төлөвлөж болно. (өөр өөр

өндөртэй барилгажилтын үед өвчтөний палатны цонхоор дээвэр дээрх ногоон байгууламж харагдаж байхаар төлөвлөх нь тохиромжтой).

- 16.6. Эдэлбэр газрын ногоон байгууламжид ялангуяа хүүхдийн эмнэлгийн байгууллагад харшил үүсгэдэг, хортой, өргөстэй, өвчтөнүүдэд ямар нэгэн аюул учруулах ургамлыг тарьж ургуулж болохгүй.
- 16.7. Удаан хугацааны эмчилгээ хийдэг эмнэлгийн (сэтгэц мэдрэлийн, сүрьеэгийн, нөхөн сэргээх эмчилгээний) эдэлбэр газарт ногоон байгууламж бүхий цэцэрлэг төлөвлөнө.
- 16.8. Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэд хэрэглэх суулгацын материал, зүлэгжүүлэх, ургамалжуулах талбайн хэмжээ болон технологийн бусад тавих шаардлагуудыг холбогдох норм, дүрэм, стандартын шаардлагыг дагуу гүйцэтгэнэ.

17. ЭМНЭЛГИЙН ХАШАА, ХАЙС

- 17.1. Хэвтэн эмчлүүлэх хэсэгтэй эмнэлгийн барилга мөн түүнчлэн сувиллын эдэлбэр газар хашаагаар хүрээлэгдсэн байх хэрэгтэй. Сэтгэц мэдрэлийн хэвтэн эмчлүүлэх эмнэлгийн эдэлбэр газрын хашаа нь гудамж талаас барилга харагдахгүйгээр төлөвлөгдөх ёстой. Хэвтэн эмчлүүлэх хэсэгтэй эмнэлгийн хашааны өндөр 1.6м, харин сэтгэц мэдрэлийн хэвтэн эмчлүүлэх эмнэлгийн хашааны өндөр 2.5м-с багагүй байна.




Зураг 13. Эмнэлгийн хашааны төрөл

- 17.2. Эмнэлгийн хашаа нь энгийн шугаман, авирахаас хамгаалсан бат бөх хийцтэй хашаа байна.

- 17.3. Хашааны өндөр 1600 мм, тулгуур хоорондын зай 2500 мм хүртэл, сараалж төмөр □20мм, хоорондын зай 110мм-ээс ихгүй, хөндлөн болон босоо профиль төмрийн хэмжээ 25x50x25x2мм байна.
- 17.4. Хашааны материал PVC болон резин бүрээс бүхий зэвэрдэггүй ган төмөр байна. Хашааны бүрдэл хэсгийг холбож угсрах, эвдэрсэн хэсгийг солих буюу засахад хялбар байвал зохино.
- 17.5. Хашааны суурь тулгуурын бэхэлгээ болон суурийн бетоны эд анги B20 -оос багагүй, хүйтэн тэсвэрлэлт 50 мөчлөгөөс багагүй байна. Тухайн барилгын загвар, дизайнтай уялдуулан суурийг гадна өнгөлгөөний чулуун болон бусад материалаар өнгөлж болно.
- 17.6. Хашааг суурилуулахдаа БНБД 3.01.06-90 болон UCS 0001-02:2019 Хашаа, хайс, хашлаганд тавигдах ерөнхий шаардлагад заасан технологи, шаардлагын дагуу хийж гүйцэтгэнэ.

18. САНДАЛ, СҮҮДРЭВЧ

- 18.1. Эрүүл мэндийн байгууллагын нийтийн эзэмшлийн талбай болон олон нийтийн орон зай, амралт чөлөөт цаг өнгөрүүлэх газарт үйлчлүүлэгчийн ая тутхай байдлыг хангах үүднээс сандалын тоог нэмэгдүүлэх шаардлагатай.
- 18.2. Сандлын суух хэсэгт ашиглагдах материал нь дулаан, суудлын өндөр, түшлэг, гарын тавиур нь хүнд ээлтэйгээр хийгдсэн байх.
- 18.3. Сандлыг байрлуулах нь нээлттэй орон зайн сүлжээгээр явган зорчигчийн хөдөлгөөний эрчмийг дэмжих явдал бөгөөд үзэгдэх орчин сайтай, нам гүм болон чимээ шуугиан ихтэй газар суух сонголтуудыг бий болгосон байх.
- 18.4. Сандлыг энэхүү стандартад заасан байрлуулах удирдамжийн дагуу байрлуулж, бат бөх суурилуулсан байна.
- 18.5. Нийтийн эзэмшлийн сандлын стандарт хэмжээг хүснэгт 7-д үзүүлэв.



Зураг 14. Сандал, сүүдрэвчний харагдах байдал

Хүснэгт 7. Нийтийн эзэмшлийн сандлын стандарт хэмжээ

Таних тэмдэг	Хэмжээний нэр	Хэмжээ /мм/
B	Суудлын өргөн	1800 – 2000
H	Суудлын өндөр	450 (±20)
D	Суудлын үр ашигт гүн	450 – 500
h	Суудлаас дээших түшлэгийн дээд ирмэгийн өндөр	500 – 800
R1	Суудлын ирмэгийн матийсан радиус	20 – 50
R2	Түшлэгийн дээд ирмэгийн матийсан радиус	20 – 50
a	Суудлын налуугийн өнцөг	0 – 4 градус
b	Түшлэгийн налуугийн өнцөг	95 – 106 градус

/Дэлгэрэнгүйг UCS 1404C:2020 Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулах сандалд тавигдах шаардлага-с үзнэ үү/

19. ГАДНА ОРЧНЫ ЗАМ ТАЛБАЙН ГЭРЭЛТҮҮЛЭГ

- 19.1. Гэрэлтүүлэг нь эрүүл мэндийн барилга байгууламжийн онцлогоос шалтгаалан зайлшгүй төлөвлөх шаардлагатай учраас зураг төсөл гүйцэтгэхээс эхлүүлэн төлөвлөн, хийж гүйцэтгэнэ.
- 19.2. Эрүүл мэндийн байгууллагын гэрэлтүүлэгчийн тусгалыг эмнэлгийн цонх болон яаралтай тусламжийн машины орц гарц хэсгийг гялбуулахааргүй, авто зам болон явган хүний замыг гэрэлтүүлэхээр хийж гүйцэтгэнэ.
- 19.3. Гэрэлтүүлгийн төрөл ангилал, ган багана, өнгө, суурьлуулах техник зэргийг Монгол улсын үндэсний стандарт “Гэрэлтүүлгийн ган багана. Техникийн шаардлага” MNS 2568 болон “Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд байршуулах гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавигдах шаардлага” UCS 1901B -ийг мөрдлөг болгоно.

Хүснэгт 8. Гэрэлтүүлгийн өндөр болон байрлуулах зай

№	Гэрэлтүүлгийн өндөр /м/	Гэрэлтүүлэг хоорондын зай /м/	Гудамжны өргөн /м/	Натрийн чийдэн /ватт/	LED чийдэн /ватт/
1	5-6	15-20	6-7	100	30-60
2	6-8	18-24	7-10	150	60-80
3	8-10	24-30	10-12	250	100-120
4	10-13	30-39	12-15	400	150-200


- 19.4. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө гэдэгт дараах зүйлсийг ойлгох бөгөөд холбогдох Хотын стандарт арга зүйн удирдамжид “Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө”-д хамаарах баримт бичгийг мөрдлөг болгоно (Хүснэгт 9). Үүнд:

Хүснэгт 9. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн нэр хамаарах арга зүйн удирдамжийн дугаар

№	Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн нэр	Баримт бичгийн дугаар
1	Нийтийн бие засах газар	UCS 1401B
2	Усан оргилуур	UCS 1402B
3	Хөшөө, архитектурын байгууламж	UCS 1404B
4	Чийрэгжүүлэх төхөөрөмж бүхий талбай	UCS 1403B
5	Хүүхдийн тоглоомын талбай	UCS 1405B
6	Спорт талбай	UCS 1406B
7	Амрах талбай	UCS 1407B
8	Мэдээллийн самбар	UCS 1401C
9	Саравч, сүүдрэвч	UCS 1402C
10	Нийтийн эзэмшлийн зам талбайн хогийн сав	UCS 1403C
11	Сандал	UCS 1404C
12	Хашаа, хайс, хашлага	UCS 1405C

20. БАЙГУУЛЛАГЫН НЭРИЙН ТЭМДЭГ, БАЙРШЛЫН МЭДЭЭЛЭЛ

- 20.1. Эрүүл мэндийн байгууллага үйлчилгээгээ иргэдэд ойлгомжтой, чирэгдэлгүй, шуурхай байдлаар тав тухтай орчинд үзүүлэх нөхцөл боломжийг онцгойлон анхаарч үйл ажиллагаа явуулж байгаа барилгын гадна талд байгууллагын нэрийн тэмдгийг байршуулна.
- 20.2. Эрүүл мэндийн байгууллага бүр байгууллагын гадна хаягийг “Төрийн байгууллагын нэрийн тэмдэг, байрлуулах удирдамж” UCS 2101A -ийн дагуу хийж байрлуулна.
- 20.3. Байгууллагын нэрийн тэмдгийн загвар, хэмжээнд тавигдах шаардлагыг Зураг 15-т үзүүлэв.



Зураг 15. Байгууллагын нэрийн тэмдэг


Байгууллагын төрөл: Төв эмнэлэг, Төрөлжсөн эмнэлэг, Дүүргийн эмнэлэг, Өрхийн эмнэлэг

Самбар: Өргөн 70-120 см, Өндөр 45-70 см

Бичвэр: Жишээ нь: Улсын Нэгдүгээр төв эмнэлэг

Материал: Саарал нерж материал дээр хар өнгөөр бичнэ

20.4. Байгууллагын нэр байршлын мэдээллийн самбарыг “Хотын стандарт - Мэдээллийн самбар” UCS 1401C -ийн дагуу хийж барилгын гадна талд гол хаалганы ойролцоо, барилгын дотор талд угтах үйлчилгээний хэсэг мөн цахилгаан шатны хэсэгт байрлуулна.



Зураг 16. Мэдээллийн самбар, хэмжээ

- 20.5. Нэг барилгад олноороо байрлаж үйл ажиллагаа явуулдаг эмнэлгийн байгууллагууд “Байгууллагын нэр байршлын мэдээллийн самбар” дээр байгууллагын нэр, давхар, өрөөний дугаарыг бичиж байрлуулна.
- 20.6. Нэг хашаанд эмнэлгийн цогцолбор барилга байрладаг бол барилгын зүг чиг заах самбарыг үйлчлүүлэгчдэд ойлгомжтой байдлаар хийж гүйцэтгэн, хашаан дотор байршуулна.
- 20.7. Самбарын бичвэр нь харагдахуйц, гаргацтай, дотроосоо болон гаднаас гэрэлтүүлэгтэй, аудио болон дүрст видео төхөөрөмжөөр тоноглогдсон байж болно. Самбарын жишиг загварыг Зураг 16-т үзүүлэв.

21. БАЙГУУЛЛАГЫН НЭРИЙН БИЧВЭР

- 21.1. Эрүүл мэндийн байгууллага өөрийн үйл ажиллагаа явуулж байгаа барилгын ойролцоо, гадна хана, дээврийн хэсэгт эмнэлгийн нэрийг том хэмжээгээр бичих буюу биет хэлбэрээр байрлуулж болох бөгөөд нэрийн бичвэрт “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5283 болон “Байгууллагын нэрийн тэмдэг, нэрийн бичвэр байрлуулах удирдамж” UCS 2101A -ийг мөрдлөг болгоно (Зураг 17).



Зураг 17. Байгууллагын нэрийн бичвэрийн жишээ

- 21.2. Барилгын гадна талд байрлуулах байгууллагын нэрийн бичвэрийг “Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай” (ЗГ -ын 37 -р тогтоол, 2013 он) тогтоолын дагуу Монгол хэл /кирилл/-ээр үг, үсгийн алдаагүй бичих бөгөөд Монгол бичиг /уйгуржин/ -ээр бичиж болно.
- 21.3. Шаардлагатай тохиолдолд байгууллагын нэрийн бичвэрийг англи хэлээр бичиж болох бөгөөд англи хэл дээрх бичвэр нь монгол бичвэрийн доод талд байрлаж, түүнээс 2 дахин бага өндөртэй байх, эсхүл Монгол /кирилл/ бичвэрийн зүүн гар талд байрлаж, түүнтэй ижил өндөртэй байна.
- 21.4. Гадна талд байрлуулсан нэрийн бичвэр нь гадна талаасаа аль эсвэл дотор талаасаа гэрэлтүүлэгтэй байж болно.
- 21.5. Байгууллагын нэрийн бичвэрийг байрлуулахдаа цахилгаан болон барилга угсралтын аюулгүй ажиллагааны талаарх холбогдох норм, стандартыг баримтлах ба байрлуулахдаа бичвэр нь тухайн барилга болон хөрш зэргэлдээ объектын цонх, хаалга, үзэгдэх орчныг халхлахгүй байна.

22. ХОГ ХАЯГДАЛ

22.1. Эрүүл мэндийн байгууллагаас үүсэж буй нийт хог хаягдлыг энгийн болон аюултай гэж ангилна. (МУ-ын эрүүл мэндийн сайдын тушаал А/505)

22.1.1. Энгийн хог хаягдлыг дотор нь ахуйн ба дахивар нөөц гэж ангилна.

22.1.2. Аюултай хог хаягдлыг дотор нь халдвартай, хурц иртэй, эмгэг, эмийн болон эсэд хортой нөлөөтэй, химийн бодисын болон цацраг идэвхт хог хаягдал гэж 6 ангилна.

		
Түр хадгалах байранд гадны хүн орохыг хориглоно	Халдвартай болон хурц үзүүртэй, иртэй хог хаягдлын био аюулгүйн таних тэмдэг	Химийн бодис болон эмийн хог хаягдлын таних тэмдэг

Зураг 18. Эмнэлгийн хог хаягдлыг таних тэмдэг

22.2. Эмгэг болон химийн бодисын хог хаягдлыг зориулалтын уутанд хийж аюултай хог хаягдал цуглуулах саванд хийнэ. Эмнэлэг нь аюултай хог хаягдлын зарим үйлчилгээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

22.3. Эмнэлгийн аюултай хог хаягдал түр хадгалах зориулалтын байртай байх ба хогийн сав нь Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

- Түр хадгалах байранд тавигдах шаардлага:
- Гаднын хүн орохооргүй, нийтийн хөдөлгөөнөөс зайтай газарт байрлаж шувуу, амьтан орох боломжгүй, цоожтой байх,
- Шал нь ус нэвтрүүлэхгүй хатуу хучилттай байх,
- Хана, тааз, шал нь угааж цэвэрлэх, халдваргүйжүүлэхэд тохиромжтой байх,
- Цахилгаан, цэвэр бохир усны төв шугамд холбогдсон байх,
- Тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэх зам талбайгаар хангагдсан байх,
- Нарны гэрэл шууд тусахгүй, сэрүүн (18° С хүртэл, 60%-аас ихгүй чийглэлтэй), агааржуулалт сайтай байх,
- Аюултай хог хаягдлыг төрөлжүүлэн хадгалах хэсгүүдтэй байх,
- Хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын түр хадгалах байранд халдвартай хог хаягдлыг халдваргүйжүүлэх хэсэгтэй байх,
- Хог хаягдлыг халдваргүйжүүлэх хэсэг нь агааржуулалтын системтэй байх,
- Хана нь 2,0 метрээс доошгүй өндөртэй байх,
- Шал нь бохир ус цуглуулах сувагт холбогдсон байх,
- Халдваргүйжүүлсэн хог хаягдлыг бутлах төхөөрөмжтэй байж болно.

Түр хадгалах цэгт тавигдах шаардлага:

- Гаднын хүн орохооргүй, нийтийн хөл хөдөлгөөнөөс зайтай газарт байрлаж, шувуу, амьтан, орох боломжгүй, цоожтой байх,
- Шал нь ус нэвтрүүлэхгүй хатуу хучилттай байх,
- Хана, тааз, шал нь угааж цэвэрлэх, халдваргүйжүүлэхэд тохиромжтой байх,
- Нарны гэрэл шууд тусахгүй, сэрүүн (18°C хүртэл, 60%-аас ихгүй чийглэлтэй), агааржуулалт сайтай байх,
- Аюултай хог хаягдлыг төрөлжүүлэн хадгалах хэсгүүдтэй байх,
- Хог хаягдлыг жинлэх зориулалттай, 0,1-120 кг хүртэл жинлэх боломжтой тавцантай, электрон жинтэй байх,

22.4. Аюултай хог хаягдал тээвэрлэх савны гадна талд 100 мм х 100 мм-ээс багагүй ромбо хэлбэрийн дүрстэй, ижил өнгийн давхар хүрээтэй (дотор талын хүрээний өргөн 5 мм) “Биоаюултай” таних тэмдгийг тавьж, доод өнцөгт нь бичнэ. Тус таних тэмдгийн дотор талд “Халдвартай эд зүйл” гэсэн тэмдэглэгээ

22.5. Хог хаягдлыг тус тусдаа цоожтой хаалгатай 3 тасалгаатай, ус нэвчихгүй бетон шалтай, халаалтгүй, ердийн салхижуулалттай хөнгөн чанарын барилга /мод, сэндвич, төмөр амбаар/ барина. Эсвэл тус бүр нь цоожтой тагтай хогийн савнуудыг хашаагаар хүрээлэгдсэн саравч бүхий талбайд байрлуулж болно. Хогийн савнууд байрлуулах талбай нь хогийн савны сууринаас тал бүр тийшээ 1.5м-ээр илүү хэмжээ бүхий ус нэвтэрдэггүй хатуу хучилтаар хучигдсан байх ба хашаа нь 1.6м-с багагүй өндөртэй байна. Саравч болон хашаа нь хогийн савны талбайн байгалийн салхижуулалтад саад болох ёсгүй. Хог хаягдлын талбайн хажууд хог ачих авто тээврийн хэрэгслийн эргэх болон маневр хийх зай төлөвлөнө.



Зураг 19. Эмнэлгийн хог хаягдал түр хадгалах цэгийн харагдах байдал/ жишээ зураг



23. ЭНГИЙН ХОГ ХАЯГДАЛ

23.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1.3–д заасны дагуу хог хаягдлыг хаяхдаа ангилан ялгах үүрэгтэй бөгөөд ялгах таних тэмдгийг зөв ашиглах нь аливаа хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах үйл ажиллагаанд чухал үүрэгтэй. Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага стандартын дагуу тээвэрлүүлнэ.

23.2. Зааварчилгааны тэмдгийг үндсэн болон нэмэлт тэмдэг гэж ангилна.

23.3. Дахивар хог ялгах таних тэмдгийн хэмжээг (Хүснэгт 10-д) үзүүлэв.

Хүснэгт 10. Дахивар хог ангилан ялгах тэмдэг

Үндсэн тэмдэг 340мм x 240мм	Туслах тэмдэг /Том/ 570мм x 200мм	Туслах тэмдэг /Жижиг/ 370мм x 120мм
		 C86 M21 Y81 K6
		 C0 M60 Y100 K0
		 C88 M52 Y0 K0
		 C75 M68 Y67 K90
		 C20 M100 Y100 K12
		 C0 M0 Y0 K100

Хогийн саванд тавигдах шаардлага:

1. Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн
2. Галд тэсвэртэй материалаар хийгдсэн
3. Хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас

сэргийлсэн байна.



Зураг 20. Ангилан ялгах тэмдэг бүхий хогийн сав

- 23.4. Энгийн хог хаягдлыг зориулалтын, битүүмжлэлтэй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. (Хог хаягдлын тухай хууль 14 дүгээр зүйлийн 6 дахь заалт)
- 23.5. Хог ачих талбай тэгш гадаргуутай, хонхор гүдгэргүй, хучилттай, автомашин ба механизм эргэх, тойрох, өргөх хөдөлгөөн хийхэд саадгүй байлгана. (MNS 5344:2011-ийн 7.3)
- 23.6. Эмнэлгийн барилгын эдэлбэр газарт аж ахуйн ба эмнэлгийн хог хаягдлыг зайлуулах, хангамжийн болон аж ахуйн машинуудад зориулсан аж ахуйн талбайг тусад нь төлөвлөж өгнө.



Зураг 21. Хог хаягдал ангилах цэгийн харагдах байдал

24. ОНЦГОЙ НӨХЦӨЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Энэхүү бүлэгт эмнэлгийн барилга байгууламжийг төлөвлөхдөө онцгой тохиолдолд хэрэглэгдэх нисдэг тэрэгний зогсоол, галын аюулгүй байдал, болзошгүй гамшгийн үед цугларах талбай зэргийг холбогдох хууль, норм, дүрэм, стандартын дагуу төлөвлөх тухай тодорхойлно.

24.1. НИСДЭГ ТЭРЭГНИЙ ЗУРВАС

24.1.1. Эмнэлгийн байгууллагын эдэлбэр газарт онцгой нөхцөлийн үед, холын зайнаас тээвэрлэх үед нисдэг тэрэг буух талбай төлөвлөхийг зөвшөөрнө. Нисдэг тэрэг буух хамгийн бага талбай нь 15х15м байна. Талбайн хамгийн их налуу 3 градусаас хэтэрч болохгүй. Нисдэг тэрэгний талбайн эргэн тойрны 20м радиус дотор ямар нэгэн саад болох зүйл байж болохгүй ба үүнд 1м-с дээш өндөртэй мод болон бут байрлуулахыг хориглоно. Зургийн даалгаврын дагуу нисдэг тэрэгний талбай нь барилгын дээвэрт байрлаж болно. Энэ нөхцөлд талбайн хамгийн бага хэмжээ нь 15х12м байна. (Зураг 22)



Зураг 22. Эмнэлгийн нисдэг тэрэгний зурвас

24.2. ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Эмнэлгийн барилга нь үйл ажиллагаанаас хамаарч тусгай зориулалтын эмнэлгийн тоног төхөөрөмж, хий, химийн бодис, аюултай хог хаягдал зэргийг агуулсан өрөө тасалгаануудтай байдаг бөгөөд тэдгээр нь гал илрүүлэх, гал унтраах тусгай зориулалтын систем тоноглолуудтай байдаг. Мөн зарлан мэдээлэх, нүүлгэн шилжүүлэлт, холбоо, тусламжийн системүүдтэй байх ба тэдгээр бие даасан дэд системүүдтэй мэдээлэл солилцож, нэгдмэл ажиллагаатай байх ёстой.

24.2.1. Эмнэлгийн барилга байгууламжийн байршил, галын болон аюулгүй ажиллагааны урсгал хөдөлгөөнийг харуулсан тойм зургийг нийтэд харагдахуйц газар байрлуулсан байна.

24.2.2. Эдэлбэр газарт галын гидрантын люк заавал төлөвлөнө.

24.2.3. Барилгын гадна галын гидрантыг байнга бэлэн байдалд байлгаж, өвөл

- хөлдөхөөс хамгаалан дулаалж цэвэрлэсэн байна. Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн эзэмшлийн талбайн 50 м доторх гадна галын гидрантын бүрэн бүтэн байдалд хяналт тавивал зохистой.
- 24.2.4. Олон нийтийн барилга байгууламжийн давхар бүрд 2-оос дээш бага, дунд оврын гал унтраагуурыг байрлуулна.
- 24.2.5. Барилга байгууламжийн гадна байрлах галын гидрант, галын шат, гал унтраах багаж хэрэгсэл шөнийн цагт ашиглахад зориулсан гэрэлтүүлэгтэй байна.
- 24.2.6. Барилга байгууламж, задгай агуулах, галын гадна шат, гал унтраах автомашины усны эх үүсвэрт хүрэх зам гарц, хонгил, нүхэн гарц нь автомашин явах бүрэн бололцоотой, өвлийн цагт цас, мөснөөс цэвэрлэгдсэн байнгын бэлэн байдалд байна.
- 24.2.7. Галын аюулгүй байдлын систем нь эмчлүүлэгсдэд зориулсан барилгын эзлэхүүн-төлөвлөлтийн, хийцийн болон инженерийн шийдлүүдийг хамаарах бөгөөд гал түймрийн үед барилгаас эмчлүүлэгсэд болон эмнэлгийн ажилтнуудыг нүүлгэн шилжүүлэх ажиллагааг хангуулахад оршино.
- 24.2.8. Гал тархахаас хамгаалах эзлэхүүн-төлөвлөлтийн ба хийцийн шийдлүүдэд тавигдах шаардлагууд:
- 24.2.9. Галд тэсвэрлэх хязгаар нь холбогдож байгаа барилгуудын хязгааруудаас багагүй байх ёстой.
- 24.2.10. Аврах зам, гарцад байрлах “аврах гарц”, “аврах хаалга” зэрэг гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ нь тэжээлд байнга залгаж асаалттай байх бөгөөд үзвэрийн газарт танхимаас хүмүүс гарсны дараа унтрааж болно.
- 24.2.11. Аврах зам, гарцын гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ нь цахилгаан тасармагц ослын тэжээлээс (өөр эх үүсвэрээс) тэжээгдэн автоматаар асаж байхаар тоноглогдсон байна.
- 24.2.12. Аврах зам дахь хаалга нь дотор талаасаа түлхүүргүй чөлөөтэй онгойхоор байна.
- 24.2.13. “Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Галын аюулгүй байдал. Техникийн шаардлага”-ын стандарт болон бусад галын аюулгүй байдлын шаардлагыг тодорхойлсон стандарт, техникийн нормативыг чанд мөрдөж ажиллана.
- 24.2.14. */Засгийн газрын 2016 оны 339 тогтоолын хавсралт-Галын аюулгүй байдлын дүрэм/*
- 24.2.15. Барилга байгууламж, тээврийн хэрэгсэл гал түймэр унтраах анхан шатны багаж, хэрэгслээр хангагдсан байна. Анхан шатны багаж, хэрэгслийг өөр зориулалтаар ашиглахыг хориглоно. (Галын аюулгүй байдлын тухай хууль 19.3)
- 24.2.16. Аливаа гамшиг ослын үед байгууллага нь гарах гарцын тэмдгийг нүдэнд ил харагдах газар байршуулж, хаалгыг гарахад чөлөөтэй байлгана. (Зураг

23)




Зураг 23. Гал унтраах анхан шатны багаж

24.3. ГАМШГААС ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

- 24.3.1. Болзошгүй газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэрт гамшгийн үед түр цугларах цэгийг эмнэлгийн гадна талбайд төлөвлөж болно.
- 24.3.2. Эмнэлгийн байгууллагын гадна талбайд болзошгүй гамшгаас хамгаалах, иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор түр цугларах аюулгүй талбайн байршлыг барилгын галын гарц болон нүүлгэн шилжүүлэх байршилтай уялдаатайгаар заавал төлөвлөнө.
- 24.3.3. Түр цугларах аюулгүй талбай нь барилга байгууламжаас аюулгүй зайд, алхаад хүрэх боломжтой байршилд байх ёстой ба талбайн хувьд нүүлгэн шилжүүлэх ажиллагаа явуулах, анхны туламж үзүүлэх машин орж гарах

боломж шаардлагыг хангасан байна. (Зураг 24)



Зураг 24. Гамшгийн үед цугларах талбайн таних тэмдэг

24.4. ТЕЛЕ ХЯНАЛТЫН КАМЕР

- 24.4.1. Эмнэлгийн байгууллагын албан хаагчид, үйлчилгээний ажилтан, иргэд, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлын хэрэгцээ, хувийн болон нийтийн өмч хөрөнгийг хамгаалан, аюулгүй байдлыг хангаж, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай.
- 24.4.2. Хяналтын камерын системийг суурилуулж байнгын видео тандалт хийх нь аюулгүй байдлыг хангах, хамгаалах хамгийн үр дүнтэй аргын нэг бөгөөд энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хувь хүний нууцыг хадгалж тэдний эрхийг зөрчихгүй байхад онцгойлон анхаарах нь чухал.
- 24.4.3. Дууны, дүрсний, дуу-дүрсний мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах боломж бүхий хөдөлгөөнт болон суурин дүрс бичлэгийн техник, хэрэгсэл нь Монгол Улсын “Барилга, орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер, Ерөнхий шаардлага /MNS 6423:2013/, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.6 -т заасан шаардлага болон олон улсын “IP67 стандарт” -д нийцсэн байна.




Зураг 25. Теле хяналтын камер

24.4.4. Камер, хяналтын системийг байрлуулах, суурилуулах техник, зай хэмжээний ерөнхий шаардлага, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлага, камер, хяналтын төхөөрөмжийн олон улсын стандарт, материалын чанарын стандарт шаардлага хангасан байна. /цахилгааны утас, сүлжээний утас, сүлжээний төхөөрөмж, суурь, бэхэлгээ, холбоос, программ хангамж, дуран, мэдрэгч, сонсох болон зарлах, хадгалах төхөөрөмж/.

25. ТАМХИ ТАТАХ ЦЭГ

Утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэг байгуулах үйл ажиллагаанд “Тамхины хяналтын тухай хууль”, “Хотын стандарт - Утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэг” UCS 1408B -ийг мөрдлөг болгоно.

25.1. Эмнэлгийн байгууллагын орох хаалга, хүлээлгийн танхим, хонгил, бие засах газар болон бусад шаардлагатай газарт тамхи татахыг хориглосон анхааруулах тэмдэг байрлуулна. Анхааруулах тэмдгийн диаметр 14 см -ээс багагүй байна. (Зураг 26)



Зураг 26. Утаат тамхи татахыг хориглосон болон зөвшөөрсөн цэг анхааруулах тэмдэг

25.2. Утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийг барилга байгууламжид нэгээс илүүгүй байхаар тухайн аж ахуйн нэгж, байгууллага байгуулж болох ба энэ нь иргэдийг дам тамхидалтад өртүүлэхгүй байх үндсэн зорилготой байна.

25.3. Утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийг явган хүний зам дээр байрлуулахыг хориглох бөгөөд байгууламжийн төрлөөс нь хамааруулан явган хүн зорчих замаас хамгийн багадаа 5 – 10 метр зайд байрлуулна.

26. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Эрүүл мэндийн байгууллагын гадна орчны тохижилт, орчны аюулгүй байдлыг стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг шалгуур үзүүлэлт (Хүснэгт 11)-ийн дагуу хянан шалгана.

Хүснэгт 11. Гадна орчны тохижилтыг шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Эрүүл мэндийн байгууллагын гадна хаягийг Нийслэлийн Засаг даргын захирамж “Гадна хаягийн загвар батлах тухай” захирамжийн дагуу хийж гүйцэтгэсэн эсэх	☐	☐
3	Яаралтай тусламжийн машин орох орц гарцыг хүлээн авах тасагтай ойр төлөвлөсөн эсэх	☐	☐
4	Хэвтэн эмчлүүлэх эмнэлгийн хашааны өндөр 1.6м, сэтгэц мэдрэлийн хэвтэн эмчлүүлэх эмнэлгийн хашааны өндөр 2.5м-с багагүй байхаар хийж гүйцэтгэсэн эсэх	☐	☐
5	Эдэлбэр газрын хилийн периметрийн дагуу, барилгажаагүй хэсгүүдэд амьд хайс төлөвлөсөн эсэх	☐	☐
6	Барилгын цонхноос модыг 15м-с багагүй, бутыг 5м-с багагүй зайнд байрлуулж суулгасан эсэх	☐	☐
7	Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавигдах шаардлагын дагуу хийж гүйцэтгэсэн эсэх /UCS 0901B:2020/	☐	☐
8	Эмнэлгийн хашаа руу орохоос эхлэн хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай, жирэмсэн, тэрэгтэй хүүхэд түрж буй хүнд зориулсан замын налууг нормын дагуу хийж гүйцэтгэсэн эсэх	☐	☐
9	Авто зогсоолыг эмнэлгийн хүчин чадлын хэмжээнд нормын дагуу тохируулан төлөвлөсөн байх	☐	☐
10	Авто зогсоолд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зогсоолыг стандартын дагуу хийж гүйцэтгэсэн эсэх /UCS 0902:B2020/	☐	☐
11	Авто зогсоолд яаралтай тусламжийн машин механизмд зориулсан зогсоолыг стандартын дагуу хийж гүйцэтгэсэн эсэх / UCS 0902B:2020/	☐	☐
12	Эмнэлгийн гадна орчны гэрэлтүүлэг стандарт, нормын дагуу бүрэн, галын аюулаас сэргийлсэн бүрхүүлтэй эсэх	☐	☐
13	Гэрэлтүүлгийн ган багана, гэрэлтүүлэгч, нарны зай болон бусад холбох хэрэгслүүд нь бат бөх, чанарын стандарт шаардлага хангасан эсэх	☐	☐
14	Энгийн хог хаягдлыг ангилан ялгаж хаях стандартын дагуу хогийн сав байршуулсан эсэх	☐	☐
15	Эмнэлгийн аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах устгах зааврын дагуу, түр хадгалах байр эсхүл түр хадгалах цэг төлөвлөсөн эсэх	☐	☐
16	Эмнэлгийн хашаанд үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, стандартын шаардлага хангасан сандлыг байрлуулсан эсэх/ UCS 1404C:2020/	☐	☐

17	Эмнэлгийн хашаанд стандартын шаардлага хангасан хогийн савыг байрлуулсан эсэх /UCS 1403C:2020/	☐	☐
18	Эмнэлгийн барилга байгууламжийн байршил, галын болон аюулгүй ажиллагааны урсгал хөдөлгөөнийг харуулсан тойм зургийг нийтэд харагдахуйц газар байрлуулсан эсэх	☐	☐
19	Барилга байгууламжийн гадна байрлах галын гидрант, галын шат, гал унтраах багаж хэрэгсэл шөнийн цагт ашиглахад зориулсан гэрэлтүүлэгтэй гүйцэтгэсэн эсэх	☐	☐
20	Яаралтай тусламжийн нисдэг тэрэг зогсох зогсоол төлөвлөсөн бол 20м радиус дотор ямар нэгэн саад болох зүйл байрлуулаагүй байх	☐	☐

Тайлбар: Эрүүл мэндийн байгууллагын гадна орчин нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Монгол улсын Эрүүл мэндийн тухай хууль
- Монгол улсын Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль
- БД 31-115-12 Эмнэлгийн барилга (Хэвтэж эмчлүүлэх тасаг, эх барих, эмэгтэйчүүдийн тасаг, өдрийн эмчилгээний тасаг)
- БНБД 30-01-04 Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм
- БНБД 21-01-02 Барилга байгууламжийн галын аюулгүй байдал
- БНБД 21-02-02 Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм
- БНБД 21-04-05 Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл
- БНБД 21-05-10 Авто зогсоол
- БНБД 23-01-09 Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт
- БНБД 23-02-08 Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг
- БД 31-112-11 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох норм
- БНБД 31-03-03 Олон нийт иргэний барилга
- MNS 5095:2017 Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа
- MNS 6392:2013 Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага
- MNS 5973:2009 Барилга байгууламжид ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ түвшин;
- MNS 6561:2015 Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус
- MNS 6056:2009 Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар;
- MNS 6056:2009 Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, үндсэн шаардлага”
- UCS 1901B:2020 Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байршуулах гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавигдах шаардлага
- UCS 1404C:2020 Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулах сандалд тавигдах шаардлага
- UCS 1403C:2020 Нийтийн эзэмшлийн гудамж талбайд байршуулах хогны саванд тавигдах шаардлага
- UCS 0901B:2020 Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавигдах шаардлага
- UCS 0001-02:2019 Хашаа, хайс, хашлаганд тавигдах ерөнхий шаардлага, хэрэглээ
- UCS 0902B:2020 Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах шаардлага

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж -7/1
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0011



7011-8060



www.standart.ub.gov.mn



Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт,
зохицуулалтын газар